



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2001 оны 08 дугаар
сарын 08 ны өдөр

Дугаар 157

Улаанбаатар
хот

Гадаадад суралцуулах тухай

Хүлээн авах сургуулийн урилга болон сурлагын амжилт, сургалтын төлбөр, суралцах хугацааны тухай сургуулийн тодорхойлолтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Дорж овогтой Дэмчигсүрэнг урлагийн менежментийн чиглэлээр Англи улсын Юнайтэд Интернэйшнл Коллежид 2 жилийн хугацаагаар 2001-2002 оны хичээлийн жилээс эхлэн суралцуулсугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Гадаадад суралцуулах тухай" Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2001 оны 59 дүгээр тушаалын Д.Дэмчигсүрэнг суралцуулах тухай заалтыг хүчингүйд тооцсугай.

3. АНУ-ын Денвер хотын Колорадогийн Их сургуулийн магистрантурт суралцаж буй Цэгмид овогтой Энхдүүрэн, Мижид овогтой Наранчимэг нарын суралцах хугацаа 1,5 жил байсныг 0,5 жилээр сунгасугай.

4. Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Ганбат/-д, энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /Л.Баттулга/-т тус тус даалгасугай.

САЙД *Tsacumeda* А.ЦАНЖИД



үгэм: ТЗХАТ.2001.08.08.